



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ УТУГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/142/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор: С.Алтанхуяг
Утас: 261828 Цахим хаяг: altankhuyags@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Төлбөрийн акт	17
4.3 Албан шаардлага	17
4.4 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХХМТГ	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.02.25 № 07/368
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	505,074,468.26	333,818,130.54
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	299,118,574.15	72,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	299,118,574.15	72,000.00
31211	Төрийн сангийн харилцах	298,671,574.15	-
31213	Арилжааны банк дахь харилцах	447,000.00	72,000.00
33	АВЛАГА	-	179,198,271.64
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	13,974,244.93
33500	Бусад авлага	-	165,224,026.71
33510	Байгууллагаас авах авлага	-	165,224,026.71
35	БАРАА МАТЕРИАЛ	205,955,894.11	154,547,858.90
35400	Хангамжийн материал	205,955,894.11	154,547,858.90
35410	Бичиг хэргийн материал	20,724,287.37	10,188,589.06
35420	Аж ахуйн материал	23,301,858.00	22,057,669.00
35430	Сэлбэг хэрэгсэл	157,092,207.23	84,087,072.79
35440	Түлш, шатах тослох материал	4,837,541.51	38,214,528.05
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,149,767,071.16	23,994,031,798.20
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,149,767,071.16	23,994,031,798.20
39200	Биет хөрөнгө	10,886,672,844.34	23,415,657,407.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,497,153,610.95	2,497,153,610.95
39202	Хуримтлагдсан элэгдэл	(132,225,880.41)	(207,738,753.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,400,000.00	98,400,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,233,333.42)	(52,633,333.46)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	23,017,416,521.99	30,868,425,927.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(14,564,084,834.03)	(10,735,024,528.87)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	126,914,431.71	123,730,436.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	(120,744,672.45)	(91,032,963.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	914,377,012.01
39217	Ном	77,000.00	-
39300	Биет бус хөрөнгө	263,094,226.82	578,374,390.33
39301	Програм хангамж	2,002,470,040.24	1,013,172,704.03
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,864,906,313.42)	(560,328,813.70)
39303	Бусад биет бус хөрөнгө	125,530,500.00	125,530,500.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,654,841,539.42	24,327,849,928.74
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	665,174,986.57	119,905,468.28
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	665,174,986.57	119,905,468.28
41300	Өглөг	665,174,986.57	119,905,468.28
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	23,940,126.10	-
41360	Бусад өглөг	641,234,860.47	119,905,468.28
41361	Байгууллагад төлөх өглөг	625,036,040.93	119,905,468.28
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	16,198,819.54	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	10,989,666,552.85	24,207,944,460.46
51	Засгийн газрын хувь оролцоо	10,989,666,552.85	24,207,944,460.46
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,840,163,565.33	6,840,163,565.33
51200	Хуримтлагдсан үр дүн	3,953,367,185.01	16,070,334,972.62
51210	Өмнөх үеийн үр дүн	231,022,839.02	3,953,367,185.01
51220	Тайлант үеийн үр дүн	3,722,344,345.99	12,116,967,787.61
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,135,802.51	1,297,445,922.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,654,841,539.42	24,327,849,928.74

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,469,841,018.64	20,079,029,203.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,660,634,935.64	17,495,042,803.58
120	Нийтлэг татварын бус орлого	1,660,634,935.64	17,495,042,803.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,660,634,935.64	17,495,042,803.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,587,060,415.62	2,004,678,802.54
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,574,520.02	15,490,364,001.04
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,809,206,083.00	2,583,986,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,809,200,083.00	2,583,986,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,836,768,600.00	2,583,986,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	5,972,431,483.00	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000.00	0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,735,766,595.47	7,962,061,415.97
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,735,766,595.47	7,962,061,415.97
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,735,154,695.47	7,957,840,865.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,632,548,921.79	1,612,814,196.71
210101	Үндсэн цалин	1,398,094,511.96	1,563,133,590.68
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,445,000.00	49,680,606.03
210105	Гэрээт ажлын хөлс	166,009,409.83	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	207,502,350.95	213,498,493.68
210201	Тэтгэврийн даатгал	207,502,350.95	213,498,493.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	530,555,978.59	611,434,000.32
210301	Гэрэл, цахилгаан	385,133,503.36	504,743,598.53
210302	Түлш, халаалт	40,930,875.99	19,724,078.31
210303	Цэвэр, бохир ус	4,767,097.26	5,112,396.00
210304	Байрны түрээс	99,724,501.98	81,853,927.48
2104	Хангамж, бараа материалын зардал	314,881,886.84	210,029,553.18
210401	Бичиг хэрэг	206,314,457.12	125,518,747.31
210402	Тээвэр, шатахуун	52,015,400.00	32,269,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	39,173,940.22	31,603,908.87
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	17,378,089.50	20,637,897.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	515,847,096.00	421,953,256.44
210604	Урсгал засвар	515,847,096.00	421,953,256.44
2107	Томилолт, зочны зардал	0	976,000.00
210702	Дотоод албан томилолт	0	976,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,643,982,877.86	1,110,347,170.89
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	213,661,034.00	169,089,886.94
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,660,000.00	9,660,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,040,000.00	1,040,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,423.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	70,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,403,458,818.86	916,945,378.87
210807	Газрын төлбөр	3,391,692.00	3,388,470.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12,578,910.00	10,003,435.08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,889,835,583.44	3,776,788,194.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,828,000.00	10,279,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,880,007,583.44	3,766,508,294.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	611,900.00	4,220,550.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	0	2,520,000.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	2,520,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	611,900.00	1,700,550.75
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	605,900.00	1,700,550.75
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	6,000.00	0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,734,074,423.17	12,116,967,787.61
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,730,077.18	0
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	11,730,077.18	0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,722,344,345.99	12,116,967,787.61

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,840,163,565.33	196,135,802.51	231,022,839.02	7,267,322,206.86
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,840,163,565.33	196,135,802.51	231,022,839.02	7,267,322,206.86
Тайлант үеийн үр дүн	-	-	3,722,344,345.99	3,722,344,345.99
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,840,163,565.33	196,135,802.51	3,953,367,185.01	10,989,666,552.85
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,840,163,565.33	196,135,802.51	3,953,367,185.01	10,989,666,552.85
Тайлант үеийн үр дүн	-	-	12,116,967,787.61	12,116,967,787.61
2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,840,163,565.33	1,297,445,922.51	16,070,334,972.62	24,207,944,460.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН(I)	11,516,079,324.78	4,890,011,695.74
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,706,873,241.78	2,306,025,295.74
120	Нийтлэг татварын бус орлого	2,706,873,241.78	2,306,025,295.74
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,408,201,667.63	2,306,025,295.74
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,196,855,538.62	2,306,025,295.74
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	211,346,129.01	-
120009	Бусад орлого	298,671,574.15	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	8,809,206,083.00	2,583,986,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	8,809,200,083.00	2,583,986,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,836,768,600.00	2,583,986,400.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	5,972,431,483.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,198,049,787.65	5,189,058,269.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,198,049,787.65	5,189,058,269.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,414,353,172.64	4,388,191,400.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,233,362,910.81	1,630,610,096.76
210101	Үндсэн цалин	1,166,917,910.81	1,453,370,222.77
210102	Нэмэгдэл	-	128,678,490.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,445,000.00	48,561,383.73
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	178,100,875.73	212,231,659.96
210201	Тэтгэврийн даатгал	178,100,875.73	147,382,018.48
210202	Тэтгэмжийн даатгал	-	16,458,635.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	12,875,008.20
210204	Ажилгүйдлийн даатгал	-	3,228,727.14
210205	Эрүүл мэндийн даатгал	-	32,287,270.77
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	535,610,049.00	539,942,000.00
210301	Гэрэл, цахилгаан	383,217,197.81	440,676,880.88
210302	Түлш, халаалт	64,545,697.50	60,516,064.85
210303	Цэвэр, бохир ус	4,490,305.21	5,013,264.00
210304	Байрны түрээс	83,356,848.48	33,735,790.27
2104	Хангамж, бараа материалын зардал	152,080,925.40	103,843,408.49
210401	Бичиг хэрэг	67,016,320.00	50,452,095.00
210402	Тээвэр, шатахуун	46,143,000.00	33,718,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	34,724,508.40	16,206,013.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,555,500.00	1,610,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,641,597.00	1,857,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	249,296,934.00	66,250,445.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,593,175.00	1,765,095.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,022,450.00	3,842,150.00
210604	Урсгал засвар	231,681,309.00	60,643,200.00
2107	Томилолт, зочны зардал	-	976,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	976,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,054,014,477.70	1,560,112,640.55
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	762,026,031.00	658,366,399.30
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,960,000.00	5,960,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,040,000.00	1,040,000.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	137,423.00	150,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	70,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,204,547,296.70	853,062,911.25
210807	Газрын төлбөр	3,399,942.00	3,388,470.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,062,585.00	3,052,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	73,786,200.00	35,022,260.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,887,000.00	274,225,149.30
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,059,000.00	263,945,249.30
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,828,000.00	10,279,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	783,696,615.01	800,866,869.83
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	195,738,215.01	298,671,574.15
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	195,738,215.01	298,671,574.15
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,520,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,520,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	611,900.00	15,674,795.68
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	605,900.00	15,674,795.68
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	587,346,500.00	484,000,500.00
213505	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	587,346,500.00	484,000,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	6,318,029,537.13	(299,046,574.15)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	6,018,910,962.98	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,018,910,962.98	-
2200	Дотоод эх үүсвэрээр	6,018,910,962.98	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,018,910,962.98	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(6,018,910,962.98)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	299,118,574.15	(299,046,574.15)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	299,118,574.15
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	299,118,574.15	72,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,405,123,300.00	4,390,711,400.06	2,014,411,899.94	68.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,405,123,300.00	4,390,711,400.06	2,014,411,899.94	68.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,402,138,500.00	4,388,191,400.06	2,013,947,099.94	68.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,642,869,200.00	1,630,610,096.76	12,259,103.24	99.25
210101	Үндсэн цалин	1,464,000,800.00	1,453,370,222.77	10,630,577.23	99.27
210102	Нэмэгдэл	128,774,400.00	128,678,490.26	95,909.74	99.93
210103	Унаа хоолны хөнгөлөлт	50,094,000.00	48,561,383.73	1,532,616.27	96.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	221,787,400.00	212,231,659.96	9,555,740.04	95.69
210201	Тэтгэврийн даатгал	156,072,600.00	147,382,018.48	8,690,581.52	94.43
210202	Тэтгэмжийн даатгал	16,428,700.00	16,458,635.37	(29,935.37)	100.18
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,143,000.00	12,875,008.20	267,991.80	97.96
210204	Ажилгүйдлийн даатгал	3,285,700.00	3,228,727.14	56,972.86	98.27
210205	Эрүүл мэндийн даатгал	32,857,400.00	32,287,270.77	570,129.23	98.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	539,942,000.00	539,942,000.00	-	100.00
210301	Гэрэл, цахилгаан	354,362,600.00	440,676,880.88	(86,314,280.88)	124.36
210302	Түлш, халаалт	97,812,000.00	60,516,064.85	37,295,935.15	61.87
210303	Цэвэр, бохир ус	7,775,800.00	5,013,264.00	2,762,536.00	64.47
210304	Байрны түрээс	79,991,600.00	33,735,790.27	46,255,809.73	42.17
2104	Хангамж, бараа материалын зардал	133,508,300.00	103,843,408.49	29,664,891.51	77.78
210401	Бичиг хэрэг	66,899,700.00	50,452,095.00	16,447,605.00	75.41
210402	Тээвэр, шатахуун	33,727,200.00	33,718,000.00	9,200.00	99.97
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,530,600.00	16,206,013.49	13,324,586.51	54.88
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	869,400.00	1,610,000.00	(740,600.00)	185.19
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,481,400.00	1,857,300.00	624,100.00	74.85
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	207,808,100.00	66,250,445.00	141,557,655.00	31.88
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,844,000.00	1,765,095.00	7,078,905.00	19.96
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,895,800.00	3,842,150.00	2,053,650.00	65.17
210604	Урсгал засвар	193,068,300.00	60,643,200.00	132,425,100.00	31.41
2107	Томилолт, зочны зардал	1,045,400.00	976,000.00	69,400.00	93.36
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	1,045,400.00	976,000.00	69,400.00	93.36
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,377,369,000.00	1,560,112,640.55	1,817,256,359.45	46.19
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	769,375,600.00	658,366,399.30	111,009,200.70	85.57

Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,960,000.00	5,960,000.00	-	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,040,000.00	1,040,000.00	-	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	150,000.00	-	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	70,000.00	70,000.00	-	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,528,192,700.00	853,062,911.25	1,675,129,788.75	33.74
210807	Газрын төлбөр	5,580,000.00	3,388,470.00	2,191,530.00	60.73
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	3,052,600.00	3,052,600.00	-	100.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	63,948,100.00	35,022,260.00	28,925,840.00	54.77
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	277,809,100.00	274,225,149.30	3,583,950.70	98.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	264,709,300.00	263,945,249.30	764,050.70	99.71
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	13,099,800.00	10,279,900.00	2,819,900.00	78.47
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,984,800.00	2,520,000.00	464,800.00	84.43
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,984,800.00	2,520,000.00	464,800.00	84.43
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,984,800.00	2,520,000.00	464,800.00	84.43
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,405,123,300.00	4,404,685,644.99	2,000,437,655.01	68.77
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,583,986,400.00	2,582,285,849.25	1,700,550.75	99.93
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,583,986,400.00	2,582,285,849.25	1,700,550.75	99.93
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,821,136,900.00	1,822,399,795.74	1,998,737,104.26	47.69
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,821,136,900.00	1,822,399,795.74	1,998,737,104.26	47.69
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	299,118,574.15	(299,118,574.15)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	72,000.00	(72,000.00)	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	132	132	0	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	66	66	0	
620001	Удирдах ажилтан	1	1	0	
620002	Гүйцэтгэх ажилтан	60	60	0	
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	66	66	0	
650013	УТҮГ	66	66	0	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгийн өртгийг бодит үнэ цэнээр бүртгэх, гэрээний хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 10-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор С.Алтанхуяг нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа хэрэгжүүлсэн.

Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 01/14 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Үндэсний дата төв нь Монгол Улсад цахим засаглалыг хөгжүүлэх зорилго бүхий Цахим монгол, Бүртгэл мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох, Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 183 дугаар тогтоолоор байгуулагдсан бөгөөд Монгол Улсын үндэсний цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйлчилгээ эрхлэх үндсэн үүрэг бүхий улсын төсөвт үйлдвэрийн газар юм.

- Алсын хараа: Монгол Улсын мэдээллийн нэгдсэн сан бүхий байгальд ээлтэй үндэсний хэмжээний байгууллага болно.
- Эрхэм зорилго: Монгол Улсын цахим үйлчилгээний дэд бүтэц, суурь хөгжлийг бид бэхжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС-д нийцсэн боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Бодлогын баримт бичигт байгууллагын орлогын бүртгэл, бараа материалын зайлшгүй байх нөөц, дотоод хяналтын талаар нарийвчлан тусгасан зүйлгүй байна.

Үндэсний дата төв УТҮГ дотоод хяналтын нэгжгүй боловч төсөв захирагч нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*”, ерөнхий нягтлан бодогч нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “*нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*” гэж заасан хяналтын үүргээ хэрэгжүүлж ажилласан байна.

Тус байгууллагын дотоод аудитын чиг үүргийг ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хэрэгжүүлдэг боловч тайлант жил аудит хийгдээгүй тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 10,469,841.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 157,047.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 117,785.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тайлант жил үйл ажиллагааны орлого 20,079,029.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 1.9 дахин нэмэгдсэнээс төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлага бий болсон тул тайлант жилийн үйл ажиллагааны орлогын 1.5 хувь буюу 301,185.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 12,673,008.4 мянган төгрөгөөр буюу 2.1 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	299,118.6	72.0	(299,046.6)
Авлага	-	179,198.3	179,198.3
Бараа материал	205,955.9	154,547.8	(51,408.1)
Үндсэн хөрөнгө	11,149,767.0	23,994,031.8	12,844,264.8

Нийт хөрөнгө	11,654,841.5	24,327,849.9	12,673,008.4
Өр төлбөр	665,174.9	119,905.5	(545,269.4)
Засгийн газрын хувь оролцоо	10,989,666.6	24,207,944.4	13,218,277.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	11,654,841.5	24,327,849.9	12,673,008.4

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн дансны өмнөх оны үлдэгдлээс 299,046.6 мянган төгрөгөөр буурсан нь 2020 онд хэрэгжүүлсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн 5 хувийн баталгаат хугацаа дуусгавар болж нийт 11 гэрээт байгууллагад шилжүүлснээс шалтгаалжээ;
- Авлага дансны өсөлтөд хур системийн үйлчилгээ авсан 120 байгууллагын 12 сарын 165,224.0 мянган төгрөгийн үйлчилгээний нэхэмжлэл голлон нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө данс 12,844,264.8 мянган төгрөгөөр өссөн нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар “Ухаалаг засаг төсөл”-ийн хүрээнд Дархан-Уул аймагт байнгын ажиллагаатай “Tier 3” түвшний Нөөц дата ашиглалтад орж төслийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн нь нөлөөлжээ;
- Өр төлбөр данс 545,269.4 мянган төгрөгийн бууралт нь 2020 оны тендерийн барааны өглөг 307,774.2 мянган төгрөг, мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн 5 хувь болох 298,599.6 төгрөгийг төлсөнтэй холбоотой байна;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 24,207,944.4 мянган төгрөг болж 13,218,277.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт /мянган төгрөг/ 3=2-1
Б	1	2	3=2-1
Үндсэн үйл ажиллагааны орлого	1,587,060.4	2,004,678.8	417,618.4
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	73,574.5	15,490,364.0	15,416,789.5
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,836,768.6	2,583,986.4	(252,782.2)
Хөрөнгийн санхүүжилт	5,972,431.5	-	(5,972,431.5)
Нэмэлт санхүүжилтийн орлого	6.0	-	(6.0)
Үйл ажиллагааны орлого	10,469,841.0	20,079,029.2	9,609,188.2
Бараа, ажил үйлчилгээний зардал	6,735,154.7	7,957,840.9	1,222,686.2
Урсгал шилжүүлэг	611.9	4,220.5	3,608.6
Үйл ажиллагааны зардал	6,735,766.6	7,962,061.4	1,226,294.8
Үйл ажиллагааны бус зардал	11,730.1	-	(11,730.1)

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны орлогын өсөлтөд ЗГХЭГ-аас хэрэгжүүлж байгаа “Ухаалаг засаглал” төслөөс хүлээн авч байнгын ашиглалтад орсон Дархан-Уул аймагт байгуулагдсан “Нөөц дата төв”-ийн үнэ төлбөргүй шилжин ирсэн 13,575,306.1 мянга, Азийн хөгжлийн банк, Засгийн газар, Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа 3709-МОН “Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод үр ашигтай байдал төсөл” ББ-07/1-20200512/101 хүрээнд тус төвийн 1 дүгээр давхарт байрлах нөөц өрөөг тоноглогсон 833,838.5 мянга, ТӨБЗГ-ын 2021 оны А-1/996 зөвшөөрлөөр ХХМТГ-аас балансаас балансад 637,831.3 мянга, ТӨБЗГ-ын 2021 оны 200 дугаар тогтоолоор Татварын ерөнхий газраас балансаас балансад 369,813.6 мянган төгрөгийн хөрөнгө шилжин ирсэн нь нөлөөлжээ.

Тайлант жилийн үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдлын зардлын өсөлтөөс шалтгаалан бараа, ажил үйлчилгээний зардал өссөн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төв нь 2021 оны урсгал санхүүжилтийн эх үүсвэрийг 7,813,931.4 мянган төгрөг, үүнээс улсын төсвийн санхүүжилт 6,360,508.0 мянган төгрөг, өөрийн орлого 1,452,423.4 мянган урсгал зардалд 7,813,931.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сангийн яамнаас Монгол Улсын гадаад өр, зээлийн таазтай уялдуулан Улсын төсвийн санхүүжилтийг 3,776,521.6 мянган төгрөгөөр бууруулж 2,583,986.4 мянган төгрөгөөр, өөрийн орлогыг 2,368,713.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 3,821,136.9 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,408,808.1 мянган төгрөгөөр бууруулж, нийт төсвийг 6,405,123.3 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд 6,405,123.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр батлагдсан.

Гүйцэтгэлээр 2,582,285.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, өөрийн үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,822,399.7 мянган төгрөг, нийт 4,404,685.6 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлж, 68.7 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,390,711.4 мянган төгрөг буюу 68.5 хувьтай байгаа нь зардлыг санхүүжүүлэх үндсэн үйл ажиллагааны орлого тасарсан болон Мэдээллийн технологийн үйлчилгээний төлбөр зардлыг 1,675,129.7 мянган төгрөг, Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 111,009.2 мянган төгрөг, урсгал зардлыг 141,557.6 мянган төгрөгөөр дутуу зарцуулснаас шалтгаалжээ.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөг/	
	Код	Нэр			Зөрүү	Биелэлт
1	71302	Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц	6,405,123.3	4,390,711.4	2,014,411.9	68.5
1.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	5,388,335.4	3,485,623.8	1,902,711.6	64.6
1.2	80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ	700,000.0	589,068.5	110,931.5	84.1
1.3	80220	Холбооны суваг ашигласны төлбөр	51,981.6	51,980.9	0.7	100.0
1.4	80316	Цахим шилжилт арга хэмжээ	261,821.9	261,518.2	303.7	99.8
1.5	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	2,984.4	2,520.0	464.4	84.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндэсний дата төв УТҮГ нь Монгол Улсын үндэсний цахим мэдээллийн хадгалалт, хамгаалалт, боловсруулалтын үйлчилгээ эрхлэх үндсэн үүрэг бүхий улсын төсөвт үйлдвэрийн газар юм. Албан хаагчид нь нууцын 2, 3 дугаар зэрэглэлтэй мэдээллийн технологийн салбарын мэргэжлийн хүмүүсээс бүрддэг.

Засгийн газраас баталсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээнд мэдээллийн технологийн салбарын албан хаагчийн цалингийн сүлжээг тусгайлан батлаагүй тул эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээг мөрдөх зохицуулалттай.

Энэ сүлжээний цалин нь мэдээллийн технологийн салбарын ажилчдын дундаж цалингаас хэт доогуур учир туршлагатай ажилчид ажлаас гарах, банк санхүүгийн байгууллага болон бусад өндөр цалин хангамжтай байгууллагуудад шилжин ажилладаг зэрэг нь тус байгууллагын цаашдын хөгжил дэвшилд сөргөөр нөлөөлөхөөр байна. Тиймээс Засгийн газар мэдээлэл технологийн салбарын албан тушаалын цалингийн сүлжээг шинээр батлах шаардлага байна.

3.8 Аудитын гол асуудал

Төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас төсвийн төсөлтэй холбоотой тайлбар, тодруулгыг харгалзахгүйгээр төсвийг үндэслэлгүй хасаж байгаа нь төлбөрийн асуудлаас шалтгаалан онц чухал дэд бүтцийг цахилгаанаар хязгаарлах, программ хангамжийн лиценз сунгагдахгүй байж улсын цахим мэдээллийн баазад доголдол үүсэх зэрэг эрсдэлийг бий болгож байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Үндэсний дата төв УТҮГ 2021 онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нийт 3,523,869.6 мянган төгрөгийн 168 мэдээллийг ил тод байршуулахаас 27,451.6 мянган төгрөгийн 1 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага 2009 оноос хойш Засгийн газраас тогтоосон төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг мөрдөөгүй, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/09 /үндэслэл алдаатай/ тушаалаар баталсан албан тушаалын цалингийн сүлжээг мөрдөж ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1. “Улсын төсөвт үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, албан газартай нэгэн адил эрхтэй”, Засгийн газрын 2019 оны 472 дугаар “төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээг хууль, тогтоомжид нийцүүлэх талаар албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, цалингийн сүлжээ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Засгийн газрын тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 99.7 хувийн хэрэгжилттэй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн шилэн дансны цахим хуудсанд 39 мэдээг хугацаа хоцроож, 6 мэдээг байршуулаагүй зөрчилд өгсөн 1 албан шаардлагын биелэлт 99.4 хувь, 11,800.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	-	1	-	-	-	99.4
Зөвлөмж	2	11,800.0	2	11,800.0	-	-	100.0
Нийт дүн	3	11,800.0	2	11,800.0	1	-	99.7

Өгсөн зөвлөмжийн дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 51 дүгээр тогтоолын дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 188 нэрийн 12,972.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 43 нэрийн 4,124.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгөд шинээр үнэ тогтоолгож, нягтлан бодох бүргэлд тусгасан, мөн ашиглалтгүй 138,000 ширхэг 11,800.0 мянган төгрөгийн үнэ бүхий “Лавлагааны үнэт цаас”-ыг УБЕГ-т шилжүүлж, уг үнэт цаасыг актаар хүлээлгэн өгч баталгаажуулсан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Компьютер, техник хангамж, сүлжээний тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа богино байдгаас шалтгаалан тайлант жил нийт 112 нэр төрлийн 739,796.6 мянган төгрөгийн анхны үнэ бүхий үндсэн хөрөнгө хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт бүртгэлээс хасуулахаар албан хүсэлт хүргүүлсэн байна.

Дараагийн аудитаар уг хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулан бүртгэлээс хассан эсэхийг шалгах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,007,106.0 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 833,838.5 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 5,432.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 158,175.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 9,660.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 5 алдаа, зөрчлийн дүн 173,267.5 мянган төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 301,185.4 мянган төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар Вертексмон ХХК-иас 2019 онд 36 нэр төрлийн 3785 нэгж 833,838.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч серверийн өрөөнд байршуулсан боловч үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй байсныг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

4.2 Төлбөрийн акт

Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-д нөөц дата төвийн гэрэл цахилгааны төлбөрийг 5,432.5 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү шилжүүлсэн төлбөрийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

1. Баталсан орон тоонд хамааралгүй, E-Mongolia төслийн нэгжийн 12 ажилтантай түр гэрээ байгуулан тус төвийн цалингийн сангаас 158,175.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн үйл ажиллагаандаа зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөх, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх албан шаардлага өгөх.

2. Тайлант оны төсвийн орлого тасарсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1 “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогын шинэ эх үүсвэр бий болгох, үйлчилгээний тарифыг шинэчлэх талаар шинжилгээ, судалгаа хийж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг судлах, төсвийн төлөвлөлтийг бодитой хийх, албан шаардлага өгөх.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь судалгаа, шинжилгээнд үндэслээгүй, байгууллагын онцлогийг тусгаагүй, хэт ерөнхий байдлаар хийгдсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, УСНББОУС 3 “Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм,

журам, тогтсон практик юм” гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практикийг тусгах талаар албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндэсний аудитын газар, Үндэсний дата төв, Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн хооронд 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан ҮАГ/АА2021-209 дугаар бүхий гэрээний 2.7 заалтыг зөрчин 9,660.0 мянган төгрөгийг Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн дансанд шилжүүлсэн байна.

Энэ нь Иргэний хуулийн 206 дугаар зүйлд “гэрээний талууд гэрээний үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Иргэний хуулийн 206 дугаар зүйлд “гэрээний талууд гэрээний үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ” гэж заасны дагуу гэрээний үүргийг зохих ёсоор, шударгаар хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар														
1	Үндэсний дата төв	АХГ-2022/142/НА-СТА-ТШЗ	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-д нөөц дата төвийн гэрэл цахилгааны төлбөрийг 5,432.5 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн байна.	Илүү шилжүүлсэн төлбөрийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх	1	5,432.5			1	5,432.5				
2	Үндэсний дата төв	АХГ-2022/142/НА-СТА-ТШЗ	Батлагдсан орон тоонд хамааралгүй, E-Mongolia төслийн нэгжийн 12 хүнтэй түр гэрээ байгуулан цалингийн сангаас 158,175.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	Санхүүгийн үйл ажиллагаандаа зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөх, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх	1	158,175.0					1	158,175.0		
3	Үндэсний дата төв	АХГ-2022/142/НА-СТА-ТШЗ	Тайлант жилийн төсвийн орлого тасарсан байна.	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, төсвийн орлогыг бүрдүүлж ажиллах	1	-					1	-		
4	Үндэсний дата төв	АХГ-2022/142/НА-СТА-ТШЗ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь судалгаа, шинжилгээнд үндэслээгүй, байгууллагын онцлогийг нарийн тусгаагүй, хэт ерөнхий байдлаар хийгдсэн байна.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практикийг тусгах	1	-					1	-		

Үндэсний дата төв УТУГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	Үндэсний дата төв	АХГ- 2022/142/НА- СТА-ТШЗ	Үндэсний аудитын газар, Үндэсний дата төв, Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн хооронд 2020 оны 12 дугаар сарын 21-ний өдөр байгуулсан ҮАГ/АА2021-209 дугаар бүхий гэрээний 2.7 заалтыг зөрчин 9,660.0 мянган төгрөгийг Нью Эстимэйтор Аудит ХХК-ийн дансанд шилжүүлсэн байна.	Иргэний хуулийн 206 дугаар зүйлд “гэрээний талууд гэрээний үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэнэ” гэж заасны дагуу гэрээний үүргийг зохих ёсоор, шударгаар хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	9,660.0							1	9,660.0	
6	Үндэсний дата төв	АХГ- 2022/142/НА- СТА-ТШЗ	Вертексмон ХХК-иас 2019 онд 36 нэр төрлийн 3785 нэгж 833,838.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч серверийн өрөөнд байршуулсан боловч үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгаагүй.	Бүртгэлгүй үндсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав	1	833,838.5	1	833,838.5							
Дүн					6	1,007,106.0	1	833,838.5	1	5,432.5	3	158,175.0	1	9,660.0	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал															
1	БЧШТ	АХГ- 2022/42/НА- СТА-ТХН	Тус байгууллага 2009 оноос хойш Засгийн газраас тогтоосон төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг мөрдөөгүй, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/09 /үндэслэл алдаатай/ тушаалаар баталсан албан тушаалын цалингийн сүлжээг мөрдөж ажилласан байна.	Албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээг хууль, тогтоомжид нийцүүлэх	1								1		
Дүн					1								1		
Нийт дүн					7	1,007,106.0	1	833,838.5	1	5,432.5	4	158,175.0	1	9,660.0	



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 28 № 19/АО160056
АКТ - 2022 М421 НА - САА - ЖМЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК-д нөөц дата төвийн гэрэл цахилгааны төлбөрийг 5,432,471.53 төгрөгөөр илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д заасныг үндэслэн гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Гэрэл цахилгааны төлбөрт илүү шилжүүлсэн 5,432,471.53/Таван сая дөрвөн зуун гучин хоёр мянга дөрвөн зуун далан нэгэн төгрөг тавин гурван мөнгө/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Үндэсний дата УТҮГ-ын захирал М.Баттулга, Ерөнхий нягтлан бодогч Д.Сүглэгмаа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
С.АЛТАНХУЯГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 69/А0160056
АХГ-2022/142/НА-СТА-ТУЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баталсан орон тоонд хамааралгүй, E-Mongolia төслийн нэгжийн 12 ажилтантай түр гэрээ байгуулан тус төвийн цалингийн сангаас 158,175,000.00 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дүгээр тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн үйл ажиллагаандаа зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг мөрдөх, зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж Үндэсний дата УТҮГ-ын захирал М.Баттулга, Ерөнхий нягтлан бодогч Д.Сүглэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.Наранчимэг

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
С.АЛТАНХУЯГ

9006109
9019120396



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 90/АО160056
АХГ-2022/142/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай


Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төсвийн орлого тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2 "Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ", 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орлогын шинэ эх үүсвэр бий болгох, үйлчилгээний тарифыг шинэчлэх талаар шинжилгээ, судалгаа хийж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг судлах, төсвийн төлөвлөлтийг бодитой хийх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж Үндэсний дата УТҮГ-ын захирал М.Баттулга, Ерөнхий нягтлан бодогч Д.Сүглэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
С.АЛТАНХУЯГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 71/А0160056

Улаанбаатар хот

АХГ-2022/142/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь судалгаа, шинжилгээнд үндэслээгүй, байгууллагын онцлогийг тусгаагүй, хэт ерөнхий байдлаар хийгдсэн байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", УСНББОУС 3 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэдэг нь санхүүгийн тайланг бэлтгэж, толилуулахдаа байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практик юм" гэсэн заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт байгууллагын мөрддөг тусгай зарчим, суурь, дүрэм, журам, тогтсон практикийг тусгах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж Үндэсний дата УТҮГ-ын захирал М.Баттулга, Ерөнхий нягтлан бодогч Д.Сүглэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
С.АЛТАНХУЯГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 72/А0160056

Улаанбаатар хот

АХГ - 2022/142/НА-СТА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу хийсэн Үндэсний дата төв УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага 2009 оноос хойш Засгийн газраас тогтоосон төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээг мөрдөөгүй, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2020 оны А/09 /үндэслэл алдаатай/ тушаалаар баталсан албан тушаалын цалингийн сүлжээг мөрдөж ажилласан байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 17.1 "Улсын төсөвт үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан "төрийн байгууллага, албан газартай нэгэн адил эрхтэй", Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан хаагчдын албан тушаалын цалингийн сүлжээг хууль тогтоомжид нийцүүлэх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж Үндэсний дата УТҮГ-ын захирал М.Баттулга, Ерөнхий нягтлан бодогч Д.Сүглэгмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
А.ДАВААДОРЖ
С.АЛТАНХУЯГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-81.Docx

CO10800269

